MERIT

Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Канадын эрчим хүчний статистикийн хөтөлбөр

Жастин Лакройкс ба Рожер Пердью

Танилцуулгын тойм

- Эрчим хүчний зах зээлийн мониторинг
- Мэдээлэл хэрэглэгчдэд зориулсан бодлогын зорилтууд
- Эрчим хүчний статистикийн мэдээллийн үндсэн хэрэглэгчид
- Эрчим хүчний статистикийн мэдээллийн түншлэгчид
- Канадын статистикийн газрын эрчим хүчний статистикийн хөтөлбөр
  - ✓ *Нүүрс, коксын судалгаа*
  - ✓ *Боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн судалгаа*
  - ✓ *Газрын тосны бүтээгдэхүүний судалгаа*
  - ✓ *Шугам сүлжээний судалгаа*
  - ✓ *Үйлдвэрлэлийн эрчим хүчний хэрэглээ*
  - ✓ *Канадын эрчим хүчний урсгал*
- Канадын эрчим хүчний урсгал

MERIT


“Хэмжих нь мэдэхийн тулд”

бөгөөд


”Хэрвээ та хэмжиж чадахгүй бол баталж чадахгүй”

Лорд Келвин

Эрчим хүчний зах зээлийг хянах: "Хувьсан өөрчлөгдөх шалгуур”



Харьцуулж болох эдийн засаг хоорондын эрчим хүчний системийн үр ашгийн томоохон ялгаа



Гадаадын хэрэглэгчдэд зориулсан бодлогын зорилтууд

- Эрчим хүч ба эдийн засаг: ДНБ, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалт, худалдаа, тээвэрлэлт, үнэ, хөрөнгө
- Эрчим хүчний аюулгүй байдал: нийлүүлэлтийн тогтвортой байдал, зах зээлийн тогтвортой байдал, гэнэтийн аюулд бэлэн байдал, эрчим хүчний системийн үр ашиг
- Эрчим хүч ба байгаль орчин: дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд үзүүлэх нөлөө

Эрчим хүчний статистикийн мэдээллийг хэрэглэгчид

- Канадын үндэсний тооцооны системийн оролт-гаралтын салбарт нийлүүлэх шаардлагатай мэдээлэл
- Статистикийн тухай хуулиар олгосон эрхийн дагуу бусад төрийн байгууллага (холбооны, мужийн гэх мэт)- тай хуваалцах мэдээлэл. Мэдээлэл хуваалцах гэрээгээр боломжит дээд хэмжээнд мэдээллийг нууцлахыг шаарддаг
- Судалгаанд оролцогчид, үйлдвэрлэлийн холбоод, үйлдвэрлэлийн шинжээчид, олон нийт хэрэглэдэг мэдээлэл.

Эрчим хүчний статистикийн мэдээллийг хэрэглэгчдээс дурдвал

Канадын байгаль орчны газар
- Хүлэмжийн хийн тооллого тооцоо

Канадын байгалийн баялагийн газар
- Эрчим хүчний системийн үр ашгийн газар
- Эрчим хүчний системийн үр ашгийн гарын авлага
- Журам ба бодлого боловсруулалт

Канадын Гадаад хэргийн яам ба Сангийн яам
- Бодлого боловсруулалт

Канадын статистикийн газар
- Үндэсний тооцооны систем
- Олон улсын худалдаа
- Байгаль орчны тооцооны статистикийн хөтөлбөр
- Тээврийн статистикийн мэдээлэл

Мужийн болон нутаг дэвсгэрийн статистикийн байгууллагууд ба Эрчим хүчний газрууд


Үндэсний эрчим хүчний зөвлөл
- Эдийн засгийн загварчлал

Олон улсын эрчим хүчний агентлаг
- Олон улсын тайлагналын шаардлагууд

Үйлдвэрлэлийн холбоод (жишээ нь, Канадын Газрын тос үйлдвэрлэгчдийн холбоо)

Хэвлэл мэдээллийн байгууллага, боловсролын байгууллага, судлаачид, олон нийт


Эрчим хүчний статистикийн мэдээллийн түншлэгчид



Канадын статистикийн газар: Эрчим хүчний статистикийн хөтөлбөр

- Ихэнх нь тооллого, үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн байгуулагуудын тооноос хамаарна
  - ✓ 9 сар бүр хийх судалгаа
  - ✓ 12 жил бүр хийх судалгаа
- Үндсэн мэдээлэл:
  - ✓ Эрчим хүчний нийлүүлэлт, хэрэгцээ, түлшний төрлөөр
    - **Нийлүүлэлт:** Үйлдвэрлэл, импорт, бараа материал, өөрчлөлт, тээвэр, нийлүүлэлт
    - **Хэрэгцээ:** дотоодын хэрэглээ, экспорт
  - ✓ Санхүүгийн мэдээлэл
  - ✓ Эрчим хүчний нийлүүлэлт, хэрэгцээний тайлан (ЭХНХТ)
    - Эрчим хүчний нийт тайлан тэнцэл (байгалийн хэмжих нэгжүүд ба 0.278 ГВт)

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ



Нүүрс ба коксын судалгаа

Канад дахь нүүрсний уурхайнуудын үйлдвэрлэл, импорт, экспорт, нөөц, нийлүүлэлт, устгал, үйл ажиллагааны орлого

- Нүүрсний судалгаа, сар бүр (# 2147 *):
  - ✓ *Хуанлийн сар бүр судалгаа хийн, Канад дахь бүх үйлдвэрлэгч нүүрсний уурхайнуудын нүүрсний үйлдвэрлэл, устгалын талаар мэдээлэл цуглуулдаг*
- Нүүрсний судалгаа, жил бүр (# 2177):
  - ✓ *Хуанлийн жил бүр судалгаа хийн, нэг сая доллароос давсан борлуулалтын орлоготой Канадад үйл ажиллагаа явуулж байгаа бүх нүүрсний уурхайнуудаас мэдээлэл цуглуулдаг*
- Коксны судалгаа, сар бүр (# 2003):
  - ✓ *Хуанлийн сар бүр судалгаа хийн, Канад дахь бүх кокжсон нүүрсний уурхайнуудаас кокжсон нүүрсний үйлдвэрлэл, устгал болон коксны зууханд түлдэг нүүрсний талаар мэдээлэл цуглуулдаг*

Боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн судалгаа (1)

Боловсруулаагүй газрын тосны статистикийн мэдээлэл, хүргэлтийн эцсийн цэг, нэмэлт, устгал зэрэг Канадын боловсруулаагүй газрын тосны үйлдвэрлэл, олборлолт

- Боловсруулаагүй газрын тос ба байгалийн хий (# 2198):

✓ *Энэхүү сар тутмын судалгаа нь боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн зохицуулалтыг хариуцан ажилладаг холбооны, мужийн болон нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн **захиргааны статистикийн мэдээллийг ашигладаг**.*

✓ *Боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн, цэвэр зардал, импорт, экспорт, дотоодын нийлүүлэлт, Канадын, мужийн болон нутаг дэвсгэрийн тооллого, тооцоонд гарах өөрчлөлтийн талаархи мэдээллийг цуглуулдаг*

Боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн судалгаа (2)

- Байгалийн хий боловсруулах (#2149);
- Байгалийн хийг хадгалах (#5210);
- Байгалийн хий нийлүүлэх (#5215):

✓Эдгээр сар тутмын судалгаагаар Канадын байгалийн хий нийлүүлэгч, тээвэрлэгчид, агуулах байгууламжийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулдаг

✓Цуглуулсан мэдээлэл нь мэдээллийн өргөн хүрээг хамардаг. Жишээ нь, шууд борлуулалт, нээлт ба хаалтын тооллого, дагалдах орлого, импорт, экспорт

✓5215-н хувьд орон сууц, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэрэглэгчдэд борлуулах асуудлыг хэлэлцэж байна.

Боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн судалгаа (3)

- Байгалийн хийн устгал (# 2167):

✓Жил тутмын судалгаа гэж “Жил бүрийн байгалийн хийн эцсийн хэрэглэгч”-г ойлгоно

✓Энэхүү судалгаагаар Канадын байгалийн хий нийлүүлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг цуглуулдаг

✓Цуглуулсан мэдээлэлд үйлдвэрлэл, уул уурхай, барилга, үйлчилгээ, худалдаа, орон сууцны эцсийн хэрэглэгчдэд борлуулсан борлуулалт (хэмжээ)-ын талаархи мэдээлэл орно

Боловсруулаагүй газрын тос, байгалийн хийн судалгаа (4)

- Байгалийн хийн тээвэрлэлт ба нийлүүлэлт (#2180):

✓Энэхүү жил бүр хийгддэг судалгаагаар үйл ажиллагааны үндсэн чиглэлнь байгалийн хийн тээвэрлэлт ба нийлүүлэлт болох Канадын компаниудын ерөнхий байр суурийн талаархи мэдээллийг цуглуулдаг

✓Судалгаагаар санхүү, хөдөлмөр эрхлэлт, орлого, тайлан тэнцлийн мэдээлэл, түүнчлэн, инженерчлэл ба үйл ажиллагааны статистикийн мэдээллийг цуглуулдаг

- Газрын тос ба хийн олборлолт (#2178):

✓Энэхүү жил тутам хийгддэг судалгааг Канадын Газрын тос үйлдвэрлэгчдийн холбоо санхүүжүүлдэг

✓Энэхүү судалгаагаар газрын тос, хий олборлох, боловсруулах, үйлдвэрлэл явуулдаг Канад компаниудын талаархи мэдээллийг цуглуулдаг

✓Судалгаагаар санхүү, орлого, тайлан тэнцлийн мэдээлэл, түүнчлэн, үйл ажиллагааны статистикийн мэдээллийг цуглуулдаг

Газрын тосны бүтээгдэхүүний судалгаа

Монгол Улс газрын тос боловсруулах үйлдвэр, газрын тосны шугам сүлжээнд их хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

- Канадын статистикийн газраас жил тутам 2 судалгаа (#2168, #5168) болон сар тутамд нэг судалгаа (#2150) явуулдаг
- Энэхүү 3 судалгаагаар муж мужаар гаргасан боловсруулах үйлдвэрийн ролт, импорт, экспорт, дотоодын борлуулалт, тооллогын түвшин зэрэг боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулдаг
- Сар тутмын боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний судалгаа нь гол судалгаа бөгөөд боловсруулсан бүтээгдэхүүнийг түлшний төрлөөр (жишээ нь, пропан, нисэх хүчин, хөдөлгүүрийн түлш, диезел, газрын тос, керосен гэх мэт) нь харуулдаг

Шугам сүлжээний судалгаа (1)

Байгалийн хий ба боловсруулаагүй газрын тосыг шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд дамжуулах ба нийлүүлэх. Үүнд орон сууц, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт байгалийн хийг хүлээн авсан болон хэрэглэсэн тухай мэдээлэл орно

- **Сар тутмын газрын тосны шугам сүлжээний судалгаа (#2191):**

✓Боловсруулаагүй газрын тос, шингэрүүлсэн газрын тосны хий (пропан, бутан, этан), боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах ба нийлүүлж байгаа мужийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх шугам сүлжээ орно

✓Мужийн нутаг дэвгэр дотор буюу дайран өнгөрөх зөвшөөрөлтэй, газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой шугам сүлжээний үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд болно.

✓Цуглуулсан мэдээлэлд шугам сүлжээ/терминалд байгаа боловсруулаагүй газрын тос, болон ижил төстэй бүтээгдэхүүн, гадны боловсруулаагүй газрын тос, нийлүүлэлтийг хүлээн авах, хэрэглэх талаархи мэдээлэл орно.

Шугам сүлжээний судалгаа (2)

- **Жил тутмын газрын тосны шугам сүлжээний судалгаа (#2179):**

✓Энэхүү судалгаагаар үндсэн үйл ажиллагаа нь боловсруулаагүй газрын тос ба бусад газрын тос цуглуулах, тээвэрлэлт болох Канад компаниудын ерөнхий байр суурийн талаархи мэдээллийг цуглуулдаг

✓Судалгаагаар санхүү, хөдөлмөр эрхлэлт, орлого, тайлан тэнцлийн мэдээлэл, түүнчлэн, инженерчлэлийн болон үйл ажиллагааны статистикийн мэдээллийг цуглуулдаг

Эрчим хүчний судалгааны хэрэглээ


Цахилгаан, байгалийн хий, пропан, диезел, мод, нүүрс, уур зэрэг олон төрлийн эрчим хүчний бүтээгдэхүүний хэрэглээ. Эрчим хүчний бүтээгдэхүүнийг олон янзаар ашигладаг тухай мэдээлэл: жишээ нь, түлш болгон ашиглах, борлуулах уур үйлдвэрлэх, цахилгаан үйлдвэрлэх, эрчим хүчний бус хэрэглээний зорилгоор гэх мэт

- Эрчим хүчний үйлдвэрлэлийн хэрэглээ (# 5047):

✓ *Энэхүү жил тутмын судалгааг Канадын байгалийн баялагийн газар болон Байгаль орчны газар санхүүжүүлдэг. Судалгаагаар Канад дахь үйлдвэрлэгч үүсгэн байгуулалтын эрчим хүчний хэрэглээг тооцож гаргадаг.*

✓ *Мэдээллийг ойролцоогоор 3,000 үйлдвэрлэгч үүсгэн байгуулалтаар жишээ аван нэгтгэв.*

КАНАДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ УРСГАЛ



Жастин Лакройкс ба Рожер Пердью КМҮБ Техникийн зөвлөхүүд Баярлалаа